

**МОНГОЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр

№02

Улаанбаатар хот

“Монгол Даатгал” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тоот тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.2 дахь заалт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 08 дугаар сарын 29-ний өдрийн 12:00 хүртэл үнэт цаасны компаниуд болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Үндсэн хуулийн гудамж 32, “Монгол даатгал” ХК-ийн байранд эчнээ санал хураалтаар явуулав.

Хурлын дарга Громов С.Б.:

2024 оны 07 дугаар сарын 19-ний өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн эчнээ санал хураалтаар “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал асуулгаар явуулах тухай” 24/22 тоот тогтоолыг компанийн тухай хуульд нийцүүлэн гаргасан.

Хуралд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, тус хурлыг зохион байгуулах комиссын дарга Т.Цацрал, Д.Аюуш Тооллогын комиссын даргаар ажилласан. Санал хураах хайрцгийг нээж байж хурлын ирцийг тогтоов.

Тооллогын комиссын дарга Д.Аюуш:

“Монгол Даатгал” ХК нь нийт 64,132,341 ширхэг хувьцаатай, саналын хайрцагнаас нийт 5 саналын хуудас гарлаа. Нийт 270 хувьцаа эзэмшигч байгаа. “Милленниум Секьюритис Менежмент Лимитед” компани 63,997,215 ширхэг хувьцаатай, Б.Бааст 466 ширхэг, Б.Дорждэрэм 155 ширхэг, Ц.Буянхишиг 137 ширхэг, Ч.Доржхорол 140 ширхэг хувьцаатай байна. Нийт саналын эрхтэй 63,998,113 ширхэг хувьцаатай буюу 99,7 хувийн ирцтэй байна.

Хурлын дарга Громов С.Б.:

Тооллогын комиссын дарга Д.Аюуш санал тоолох ажил дууссан бол саналын дүнг танилцуулна уу.

Тооллогын комиссын дарга Д.Аюуш:

Санал тоолох ажил дууслаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын дүн дараах байдалтай байна. Нийт 63,998,113 саналын эрхтэй хувьцаа эзэмшигчид саналаа өгч хэлэлцсэн бүх асуудлаар 100 хувийн саналаар зөвшөөрсөн байна. Татгалзсан санал байхгүй тул баталсанд тооцов.

Хурлын дарга Громов С.Б.:

Тооллогын комисс шийдвэрээ танилцууллаа. Үүнийг үндэслэж хурлаас гарах тогтоолыг танилцуулья.

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэг 62.1.7 дахь заалт болон 77 дугаар зүйлийн 77.4 дэх заалт, 2024 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хүртэл явуулсан эчнээ санал хураалтын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгосугай.
2. Дараах 6 нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгосугай:
 1. Громов Сергей Борисович
 2. Баяртогтохын Энхбаяр
 3. Лхагважавын Төр-Од
 4. Лизунова Таня
 5. Огай Наталья Юрьевна
 6. Гантөмөрийн Ганжаргал
3. Дараах 3 нэр дэвшигчийг ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгосугай:
 1. Сиваев Александр Владимирович
 2. Сэдбазарын Отгонбат
 3. Батмөнхийн Мөнхзул
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг Санхүүгийн Зохицуулах Хороонд бүртгүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Т.Цацрал/-д даалгасугай.
5. Компанийн эрх ашгийг дээдлэн, Компанийн тухай хууль тогтоомж, Компанийн дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

Дээрх тогтоолыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталсан болохыг та бүхэнд мэдэгдлээ.
Тус эчнээ санал хураалтыг 12:30 минутад хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:.....Т.Цацрал

ТАНИЛЦСАН ХУРЛЫН ДАРГА:.....Громов С.Б.

